

“Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн 2017” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа

Сумын Засаг даргын 2017 оны А/90 дүгээр захирамжийн дагуу 09 дүгээр сарын 13-ны өдөр “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 17 иргэн, 7 төрлийн /хүнсний ногоо, талх, нарийн боов, цагаан идээ, хоол үйлдвэрлэл, оёдол, гар урлал/ бараа, бүтээгдэхүүнээр амжилттай оролцож нийт 1,924,000 төгрөгийн борлуулалт хийлээ.

Үзэсгэлэн худалдааны шилдэг оролцогчдоор дараах иргэд шалгарлаа. Үүнд:

1. М.Цэндсүрэн – мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
2. З.Батжаргал – талх, нарийн боовны үйлдвэрлэл
3. З.Билэгбаяр – гар урлал
4. Б.Аманбек – хамгийн их ургац хураасан
5. Р.Ганхөлөг – сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

